

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
6 дугаар хавсралт

**БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙН ХЭЛТСИЙН ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГАА ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН ДЭЛГЭРСАЙХАНЫ САЙХАНЧИМЭГ
2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур Үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэл тийн хувь
			Суурь түвшин н	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)			
1	2	3	4	5		6	7	

Зорилт 1. "Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"

3.4 заалт. Улаанбаатарын онцлог бүхий аялал жуулчлалыг хөгжүүлж, эдийн засагт оруулах хувь нэмрийг нэмэгдүүлнэ

3.4.2. Аялал жуулчлалын салбарт инновацыг нэвтрүүлж, гадаад, дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлж, сурталчилгаа, маркетингийн ажлыг нэмэгдүүлнэ.

3.4.2.2. Улаанбаатар хотыг олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнгүүдэд оролцож, сурталчилан таниулна.

1.	Арга хэмжээ-1.1: "Дэлхийн аялал жуулчлалын хотуудын холбоо"- той хамтын ажиллагааг өргөжүүлнэ.	Үйл ажиллагааны Хэрэгжилтийн хувь	100%	100%	2024 онд тус газраас зохион байгуулсан арга хэмжээний талаарх мэдээллийг сайт, цахим орчинд байршуулсан. Дэлхийн Аялал жуулчлалын Хотуудын Холбооны 2024 оны Форум уулзалт нь Нью-Зеландын, Вэлингтон хотод 4-р сарын 21-23-ны өдрүүдэд "Тогтвортой хотын аялал жуулчлал" сэдвийн хүрээнд: Инновац ба бэхжүүлэлт гэсэн дэд сэдвээр хийгдсэн бөгөөд арга хэмжээний мэдээллийг Газрын дарга болон Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэн ажилласан. Тухайн арга хэмжээнд оролцох төсөв батлагдаагүй учраас оролцох боломжгүй болсон. 2024 онд зохион байгуулагдах Дэлхийн Аялал жуулчлалын хотуудын холбооны хурлыг Монгол улс Улаанбаатар хотод зохион байгуулахаар саналаа хүргүүлэн ППТ бэлтгэн ажилласан. Мөн Дэлхийн Аялал жуулчлалын хотуудын холбоотой холбогдолтой мэдээлэл бүрийг тайлагнан ажиллаж байна. 2025 онд болох хурлын талаарх мэдээллийг мөн хүргүүлэн ажиллаа.	2024.01.01 2024.12.31	100%
----	--	--	------	------	--	--------------------------	------

2.	<p>Арга хэмжээ-1.2: Улаанбаатар хотын аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг сурталчлах зорилгоор олон улсын арга хэмжээнд оролцох, зохион байгуулах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.</p>	<p>Үзэсгэлэн, арга хэмжээний тоо</p>	7	<p>- ХБНГУ-ын Берлин хотод 58 дахь удаагийн ITB 2024 олон Улсын аялал жуулчлалын үзэсгэлэн 2024 оны 03 дугаар сарын 05-07-ны хооронд зохион байгуулагдсан ба Монгол орны хувьд 20 гаруй удаа энэхүү аялал жуулчлалын үзэсгэлэнд оролцож байгаа бөгөөд Европын орнуудаас ирэх жуулчдын урсгалыг татах зорилгоор Монголын иргэний агаарын тээврийн компани, "Grace A Star Mongolia", "New Juulchin tours", "Juulchin", "Tsolmon Travel", "Nona travel Mongolia", "Golden Gobi Tours & Expedition", "Great Genghis Tours and Expeditions", "Ragusa tour", "Explore Mongolia", "Blue Silk travel", "Twin World" зэрэг 11 тур оператор оролцож, B2B уулзалтууд хийгдэв. Арга хэмжээний хүрээнд 200 гаруй улсын аялал жуулчлалын салбарынхан нэг дор хуран чуулдаг хамгийн том үзэсгэлэн юм. - "TOURISM WEEK" ОЛОН УЛСЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАРЫН ЧУУЛГАН 2024 оны 04 дүгээр сарын 15-21-ний өдрүүдэд Төрийн ордон, Блю Скай зочид буудал, MYXAYT, Корпорэйт Конвэншн Центр болов. Арга хэмжээнд ЯПОН, БНСУ, БНХАУ, ОХУ-ын бизнесийн байгууллагууд, аялал жуулчлалын салбарын төлөөллүүд, 21 аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, аялал жуулчлалын холбоод, аялал жуулчлалын салбарын эрдэмтэн багш судлаачид, хөтөч тайлбарлагч нар, аялал жуулчлалын салбарт үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуй нэгж байгууллагуудын төлөөлөл болсон 880 гаруй хүн оролцов. Хетелбэрийн хүрээнд Улаанбаатар хотын аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээг танилцуулан олон нийтэд сурталчлан ажиллав.</p> <p>- Нийслэлийн Засаг даргын А/341 захирамж Улаанбаатар хотыг олон улсад сурталчлах үзэсгэлэн арга хэмжээнд оролцоо 2024 оны 05 дугаар сарын 08-13-ны өдрүүдэд Бүгд Найрамдах Солонгос улсын Сөүл хотноо болох "Сөүлийн олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн" арга хэмжээнд Урлагийн багын 4-н төлөөлөл болон тус газраас Газрын дарга болон Бодлогын хэрэгжилтийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Туул нар явсан болно. Уг үзэсгэлэнд нийт 40 улс, 400 компани, 500 павилон, 50,000 зочин оролцсон. Энэхүү арга хэмжээний үеэр Ардын урлагийн тогтолт, Тур оператор компаниудын танилцуулга, Солонгос</p>	10	2024.01.01 2024.12.31	100%

		<p>хэл дээр хэвлэгдэн гаргасан "Улаанбаатар" сэтгүүлийг тараах зэрэг ажлуудыг хэрэгжүүлж хаалтын үеэр Монгол улс шилдэг PR Маркетинг тохижилт хийсэн улсаар шалгарсан.</p> <p>- Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Монгол улсаас БНХАУ-д суугаа Элчин сайдын яам, Монгол Улсаас БНХАУ-ын Засаг захиргааны онцгой бүс Хонконгт суугаа Ерөнхий консулын газар, Нийслэлийн аялал жуулчлалын газар болон Монголын Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо, Улаанбаатар театрын уран бүтээлчид, Хүннү Эир ХХК, тур оператор компаниудын төлөөллүүд 2024 оны 04 дүгээр сарын 22-оос 2024 оны 04 дүгээр сарын 28-ны өдрүүдэд БНХАУ Гуан Жао, Засаг захиргааны онцгой бүс Хонконг хотуудад Монгол улс Улаанбаатар хотыг сурталчлан оролцсон. Монгол Хятад хоёр орны аялал жуулчлалын хамтын ажиллагааг өргөжүүлэх, жуулчдын урсгалыг нэмэгдүүлэх, B2C арга хэмжээг зохион байгуулж Монгол улсыг Хятадад сурталчлан таниулах таатай нөхцөлийг бий болгож, Хятадын аялал жуулчлалын компаниудад өөрсдийн үйл ажиллагаа танилцуулан, Хятадын хэвлэл мэдээллийн төлөөлөгч Zaker, Sina news, Soutern metropolis daily news, Бээжингийн эдийн засгийн сонин сурвалжлагч, Хонконгийн TTG asia media Pte ltd сурвалжлагч ирж сурвалжлага авч, Хятадын томоохон дагагч бүхий блок, тикток хөтлөгч, инфлүэнсэр нар хүрэлцэн ирж өөрсдийн платформоор дамжуулан Монголыг сурталчлах рилл бичлэгүүд хийж цацсан.</p> <p>- Нийслэлийн Засаг даргын 2024 оны A/585 дугаар захирамж, тус газрын даргын 2024 оны A/16 дугаар тушаалын дагуу "Улаанбаатар травел экспо-2024" аялал жуулчлалын үзэсгэлэнг 2024 оны 05 дугаар сарын 24-26-ны өдрүүдэд Мишээл экспо төвд 10 дахь жилдээ Улаанбаатар аялал жуулчлалын холбоо ТББ-тай хамтран зохион байгууллаа. Үзэсгэлэngийн үйл ажиллагаанд БНСУ-ын КТО Улаанбаатар суурин төлөөлөгчийн газрын харьяа 17 байгууллага, БНХАУ-ын Монгол улс дахь төлөөлөгч ЗАНДУ ТРАВЕЛ ХХК, 21аймгийн төлөөлөл болох Өмнөговь, Завхан, Увс, Ховд, Дархан зэрэг аймгууд өөрсдийн аймгийн аялал жуулчлалын талаарх мэдээллийг 3 өдрийн турш өгч оролцлоо. Мөн дэмжигч байгууллагаар Улаанбаатар театр ОНӨТҮГ-н ураг бүтээлчид бүрэн бүрэлдэхүүнээрээ оролцлоо.</p>	
--	--	---	--

		<p>- Тайваний Олон улсын хамтын ажиллагааны хөгжлийн сан 2024.07.04-17-ны өдрүүдэд Тайваньд “Эко аялал жуулчлал” сургалт семинарт оролцов. Тус семинарт дэлхийн 20 улсын аялал жуулчлалын салбарын 27 төлөөлөгчид оролцож эко аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар тухайн улс орнуудын авч хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөр, аяллын бүтээгдэхүүн үйлчилгээг танилцуулах, судлах, тулгамдаад байгаа асуудлуудыг харилцан хэлэлцэж шийдвэрлэх зэрэг туршлага солилцов. Мөн Тайвань улсын аялал жуулчлалын салбарын эко аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар авч буй арга хэмжээнүүдтэй танилцаж, тухайн арга хэмжээг хэрэгжүүлж буй төрийн болон хувийн байгууллагуудын үйл ажиллагаатай танилцав.</p> <p>- Япон улсын Токио хотноо зохион байгуулагдсан ЖАТА олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд 2024.09.26-29-ны өдрүүдэд оролцсон. Үзэсгэлэнд Монгол улсаас нэгдсэн зохион байгуулалттайгаар 11 аялал жуулчлалын компани оролцсон. Нийслэлийн Аялал жуулчлалын газрын звент хариуцсан мэргэжилтэн Улаанбаатар театрны уртын дуучин, бүжигчин, морин хуурч хөөмийч 3 уран бүтээлчийг хариуцан тус үзэсгэлэнд засагдсан Монгол Улсын үзэсгэлэнгийн талбай дээр урлагийн тогтолт үзүүлэв. нийт 30 минутын 8 удаагийн тогтолтыг хийсэн. Мөн Улаанбаатар хотын сурталчилгааны 300ш сэтгүүлийг үзэсгэлэнг сонирхогчдод хүргэж сурталчилсан.</p> <p>- “ҮНДЭСНИЙ СОЁЛ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ТЕХНОЛОГИЙН ХӨГЖИЛ” уриа нь дор ITM үзэсгэлэнг 2024 оны 10 дугаар сарын 25, 26, 27-ны өдрүүдэд Мишээл экспо төвийн үзэсгэлэнгийн танхимд 25 дахь жилдээ зохион байгуулагдас. Арга хэмжээнд 21 аймаг-160 гаруй ААНБ, тур оператор, жуулчны бааз, ресторан зоогийн газар, аяллын хэрэгсэл ханган нийлүүлэгч, аяллын бүтээгдэхүүн үйлчилгээ эрхлэгч, урлаг соёлын гээд 200 гаруй аж ахуйн нэгж, бие даан оролцож тус үзэсгэлэнгийн 3 өдөрт 4000 гаруй зочид мэргэжлийн хүмүүс ирж сонирхсон.</p> <p>- БНХАУ-ын Шанхай хотод 11 сарын 22, 23, 24-нд зохион байгуулагдаж буй “China International Travel Mart 2024” ОУ-ын аялал жуулчлалын үзэсгэлэнд Монгол улсаас 12 тур оператор буюу нийт 30 гаруй хүний бүрэлдэхүүнтэй аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээгээ сурталчлан оролцсон</p>	
--	--	---	--

						бөгөөд Улаанбаатар хотын танилцуулга сэтгүүлийг 1000 ширхгийг үзэгч оролцогчдод тараан сурталчлав. Олон улсын үзэсгэлэнд нийт 47 улсын 500 гаруй байгууллагын төлөөлөл оролцов. - 2024 онд нийт 10-н үзэсгэлэнд оролцов. АНУ-д зохион байгуулагсан IMEX үзэсгэлэн, БНХАУ-ын Чиндаа болон Хонгконг-д болсон үзэсгэлэнгүүдэд төсөв батлагдаагүй учраас оролцох боломжгүй болов.		
3.	Арга хэмжээ-1.3: Улаанбаатар хотын танилцуулга сэтгүүл, цахим сэтгүүл, газрын зураг, хөтөч ном гаргах	Орчуулсан материалын хуудасны тоо	11	12		Улаанбаатар сэтгүүлтэй холбоотой нэмэлт материалуудыг орчуулганд өгч англи хэлнээс монгол, хятад, орос, герман хэл рүү орчуулах ажлыг хийж гүйцэтгэсэн. Нийт орчуулгын 12 хуудас материалыг хүлээн авсан. Мөн Койка олон улсын байгууллагын санхүүжилттэй 500 англи сэтгүүл, 500 газрын зураг хэвлүүлсэн.	2024.01 2024.04	100%
4.	Арга хэмжээ-1.4: Найрамдалт харилцаат хотод Улаанбаатар хотын соёл, аялал жуулчлалын өдрүүдийг зохион байгуулах	Үйл ажиллагааны Хэрэгжилтийн хувь	100%	100%		Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Монгол улсаас БНХАУ-д суугаа Элчин сайдын яам, Монгол Улсаас БНХАУ-ын Засаг захиргааны онцгой бүс Хонконгт суугаа Ерөнхий консулын газар, Нийслэлийн аялал жуулчлалын газар болон Монголын Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо, Улаанбаатар театрын уран бүтээлчид, Хүннү Эйр ХХК, тур оператор компаниудын төлөөлөлүүд 2024 оны 04 дүгээр сарын 29-ий өдрүүдэд БНХАУ-ын Бээжин хотноо Монгол улсыг Хятад улсад сурталчлан таниулах, Хятадаас Монгол улсад зорин ирэх жуулчдын тоог нэмэгдүүэх, тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор Найрамдалт харилцаат хотод Монгол улсын соёлын өдрийг зохион байгуулав. Арга хэмжээний үеэр Монгол гэр барин уламжлалт зан заншил, идээ ундаа, үндэсний хувцас, үндэсний урлагаяа Хятадын ард түмэнд сурталчлан танилцууллаа. Уг арга хэмжээнд Гуандун мужаас 80 гаруй аялал жуулчлалын агентууд болон 3 хэвлэл мэдээллийн хэрэгсэл, 3 инфлюенсэр нар оролцсон. Уг арга хэмжээний тухай мэдээллийг 13 видео, Хятад тик ток болон бусад олон нийтийн хэрэгслээр шууд дамжуулав. Тус арга хэмжээг зохион байгуулснаар Монгол Хятад хоёр орны аялал жуулчлалын хамтын ажиллагааг өргөжүүлэх, жуулчдын	2024.01.01 2024.06.14	100%

					урсгалыг нэмэгдүүлэх, Хятадын аялал жуулчлалын компаниудад өөрсдийн үйл ажиллагаа таниулах бололцоотой болсон. Арга хэмжээний үеэр B2B уулзалтыг зохион байгуулж хот болгонд 40 дээш Хятадын аялалын компани төлөөлөгчид оролцож, шууд бүтээгдэхүүн үйлчилгээг борлуулах боломжоор хангасан. Шууд нислэгтэй хотууд дээр тулгуурлан, илүү бүтэээмж өндөртэй, эх газрын чинээлэг жуулчдын урсгалыг нэмэгдүүлэхэд ач холбогдолтой арга хэмжээ болсон.		
5.	Арга хэмжээ-1.5: Найрамдалт харилцаат хотуудын аялал жуулчлал, соёл урлагийн өдрүүдийг Улаанбаатар хотод зохион байгуулна	Арга хэмжээний тоо	3	3	<p>- Нийслэлийн Засаг даргын 2024 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн A/647 дугаар захирамжийн дагуу "Франц соёл, аялал жуулчлалын өдруүд" арга хэмжээг Франц улсаас Монгол улсад суугаа элчин сайдын яам, Аллианс Франсез төвтэй хамтран 2024 оны 06 дугаар сарын 08-ны өдөр Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд зохион байгууллаа. Энэ жилийн арга хэмжээнд Франц хэл дээр үйл ажиллагаа явуулдаг дипломат, боловсрол соёлын байгууллагууд бизнес худалдаа, аялал жуулчлалын тур, оператор компаниуд өөрсдийн үйл ажиллагаагаа танилцуулж, Францад суралцах талаар мэдээлэл өгсөн. Өдөрлөг дээр мөн дэлхийд өргөн тэмдэглэдэг хөгжмийн баярын гайхалтай тогтолтууд, open mīc-үүд явагдсан ба Олимпийн наадам 100 жилийн дараа Парист эргэн ирснийг тохиолдуулан Парис 2024 наадмын талаар сонирхолтой мэдээллүүдийг өгч францын алдарт петанк спортын тэмцээн зохион байгуулагдсан. Мөн жуулчдад зориулсан үнэ төлбөргүй франц хэлний хичээл болон францын соёлын төвийн хичээлүүдэд хөнгөлөлттэй үнээр хамрагдах зэрэг боломжууд нээгдсэн юм. Арга хэмжээнд нийт 26-н байгууллага оролцож 3000-4000 дотоод болон гадаадын жуулчид үзэж сонирхсон.</p> <p>- Нийслэлийн Засаг даргын 2024 оны A/983 дугаар захирамжийн дагуу "Япон соёл аялал жуулчлалын өдөрлөг 2024" арга хэмжээг "Летс травел" ХХК-тай хамтран Монгол улсад суугаа Япон улсын элчин сайдын яам, Япон улсад суугаа Монгол улсын элчин сайдын яамын дэмжлэгтэйгээр 2024 оны 08 дугаар сарын 24,25-ны өдрүүдэд жанжин Д.Сүхбаатарын талбайд зохион байгууллаа. Арга хэмжээнд Японы Оита мужаас 90 гаруй</p>	2024.06 2024.11	100%

		<p>жуулчид, 170 гаруй төлөөлөгчид хүрэлцэн ирсэн ба Япон бараа бутээгдэхүүний үзэсгэлэн худалдаа, Япон хоолны амталгаа болон Японд суралцах боловсролын үзэсгэлэн мөн зохион байгуулагдсан. Өдөрлөгт нийт Бэлгү хот, Коконоз хот, Япон амт мядагмаа, Китчен Гаяс Катеринг, Кафе Де Лолита, Асахи, Ниппон наран трейд. Томоко зөгийн бал, Фүжи, Наго, Жинги монгол, Кидс Тоес Монголия (2 асар), Хүннү бичиглэл, Би жи си(2 асар), Эбисуюу удон, Мацури гэх зэрэг Япон улсын хоол, соёлыг түгзэхээр 19 аж ахуй нэгжүүд оролцсон. Арга хэмжээг цахим сайт, сошиалаар сурталчилсан бөгөөд нийт 49,100 хандалт авсан. Хоёр өдрийн арга хэмжээнд нийт 12,000 хүн ирж сонирхсон болно.</p> <p>- Нийслэлийн Засаг даргын 2024 оны 08 дугаар сарын 20-ний өдрийн А/1016 дугаар захирамжийн хүрээнд "Солонгосын соёл, аялал жуулчлалын өдрүүд" арга хэмжээг Бүгд Найрамдах Солонгос улсаас Монгол улсад суугаа элчин сайдын яамтай хамтран 2024 оны 08 дугаар сарын 30-31, 09 дүгээр сарын 01-ний өдрүүдэд жанжин Д.Сүхбаатарын талбайд зохион байгуулав. Энэ жилийн арга хэмжээнд БНСУ-ын Хойд Гёнсан мужаас-15, Жоннам мужаас-10 аж ахуй нэгж байгууллагууд хүрэлцэн ирж оролцсон бөгөөд Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй гоо сайхны 8, солонгос хоол үйлчилгээний 6, И март, таван богд, Жэжү эйр, Сэжун солонгос хэлний сургалтын төв, БНСУ-ын төрийн өмчит байгууллагууд КОЙКА, КОТРА, Ногоон Ази сайн дурын байгууллага зэрэг нийт 56 байгууллага оролцсон. Арга хэмжээний үеэр БНСУ-аас "Юн Мён Хва" Солонгос үндэсний бүкгийн хамтлаг, "НУМУРИ" амьд хөгжмийн хамтлагууд хүрэлцэн ирж уран бүтээлээ олон нийтэд танилцуулав. Мөн хетелберийн хүрээнд Солонгос ардын урлагийн үзүүлбэр, Электрик үндэсний хөгжмийн тоглолт, Жинду бөмбөрт бүжиг, Таэквондогийн үзүүлбэр гэх мэт олон сонирхолтой тоглолт, үзүүлбэрүүд зохион байгуулагдлаа.</p> <p>2024 онд нийт 3-н Найрамдалт харилцаат хотуудын соёл, аялал жуулчлалын өдрүүдийг зохион байгуулсан. Төсөв бүрэн зарцуулагдсан учраас 4-дэх соёл, аялал жуулчлалын өдрүүдийг зохион байгуулаагүй. БНХАУ болон Кувейт улсын</p>	
--	--	---	--

					соёл, аялал жуулчлалын өдрүүдийг 2025 онд зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.		
6.	Арга хэмжээ-1.6: Түүх соёлын дурсгалт 5 газар Кью Ар код уншуулж, цахим хөтчөөр дамжуулан мэдээлэл авах боломжийг бүрдүүлнэ.	Кью Ар код байршуулах дурсгалт газруудын тоо	21	-	Шинээр 5 хөшөө дурсгалт газруудын түүх болон холбогдох мэдээллүүдийг судлан ажилласан. Мөн холбогдох мэдээллүүдийг орчуулах орчуулгын төвүүдээс үнийн санал авсан. Газар зүйн байршил болон самбар, хавтангийн үнийн саналыг гарган ажилласан. Тухайн арга хэмжээнд санхүүжилт байхгүй учраас хийгдээгүй.	2024.07 2024.11	
7.	Арга хэмжээ-1.7: Улаанбаатар хотын аялал жуулчлалын маршрут, зорин очих газрууд, жуулчдад зориулсан онцлох соёл, аялал жуулчлалын арга хэмжээг Эй Ар, Ви Ар технологиор хийж гадаад улс оронд сурталчлах	Контентийн тоо	-	-	2024 оны төсөвт суугдаагүй тул үнэлгээнээс хасаж өгнө үү.	2024.07 2024.11	-

Зорилт 2. “Хуулиар олгосон чиг үүргийн хүрээнд”

Газрын дүрмийн 4.1.5. Нийслэлийн хөгжлийн бодлогод нийцүүлэн Улаанбаатар хотын аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр гадаад, дотоодын байгууллагуудтай хамтарч ажиллах;

8.	Арга хэмжээ-2.1: Шууд нислэгтэй болон найрамдалт харилцаат, ах эгч дүүс хотуудтай	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100%	100%	2024 оны байдлаар шууд нислэгтэй хот болон найрамдалт харилцаат хотууд болох Бүгд Найрамдах Солонгос улсын Сөул, Гуанжу, Намянжу, Бүгд Найрамдах Узбекистан улсын Ташкент хотуудад хийгдсэн албан томилолтуудад хамтран ажиллах саналууд	2024.01.01 2024.12.01	100%
----	--	---------------------------------	------	------	--	--------------------------	------

	хамтын ажиллагааг хөгжүүлэх				хүргүүлж, хотуудын талаарх судалгааг хийж, томилолтын талаарх үр дүнгийн тайланг бичиж ажилласан. Мөн Гадаад улсаас Монгол улсад суугаа бүх Дипломат төлөөлөгчийн газарт арга хэмжээний урилгуудыг хүргүүлж ажилласан. Тус газраас зохион байгуулагдсан Өвлийн наадам, Бүргэдийн баяр, Тэнгэр бөөгийн фестиваль, Даншиг наадам – Хүрээ цам зэрэг арга хэмжээнүүдэд Дипломат төлөөлөгчийн 28-н газарт урилга хүргүүлэхэд давхардсан тоогоор 300-400 төлөөлөгчид манай арга хэмжээнд хүрэлцэн ирсэн.		
9.	Арга хэмжээ-2.2: Олон улсын байгууллагуудтай хамтран төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	2	2	Tус газраас Бүгд Найрамдах Солонгос улсын Засгийн газрын буцалтгүй тусламжийн хүрээнд 2026 онд хэрэгжүүлэх төслийн талаарх 2 саналыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Гадаад харилцаа, хамтын ажиллагааны газарт хүргүүлэн ажилласан. Жуулчны мэдээллийн төвийг Гандантэнчэнлийн хийд дээр барих төслийг англи, монгол хэл дээр, Монгол улс Улаанбаатар хотын сурталчилгааг ББСи олон улсын сувгаар болон Дарс Фильм олон улсын контент үйлдвэрлэгчээр хийлгэх төслийг англи, монгол хэл дээр тус тус боловсруулан хүргүүлсэн. Тус газарт сайн дурын ажилтнаар Койка гаас томилогдон ирсэн багштай хамтран яармагт байрлах шинэ Засаг даргын Тамгын газарт дижитал хурлын өрөө тохижуулах төслийг боловсруулан хүргүүлсэн.	2024.01.01 2024.12.01	100%
4.1.9. Гадаад оронд зохион байгуулагдах аялал жуулчлалын хурал, зөвлөгөөн, үзэсгэлэн, арга хэмжээнд аялал жуулчлалын болон жуулчны үйлчилгээний байгууллагуудыг хамруулах;							
10.	Арга хэмжээ-2.3: Гадаад оронд зохион байгуулагдах үзэсгэлэн арга хэмжээнд байгууллагын оролцоог хангах	Арга хэмжээний тоо	7	7	2024 оны эхний улиралд зохион байгуулагдсан нийт 3-н үзэсгэлэн арга хэмжээнд байгууллагын оролцоог ханган ажилласан. Байгууллагыг төлөөлж Газрын дарга болон Бодлого хэрэгжилтийн хэлтсийн дарга С.Туул нар оролцон ирсэн ба байгууллагын сурталчилгаа, Улаанбаатар хотын аялал жуулчлалын сурталчилгааны материал зэргийг бэлтгэж, тус үзэсгэлэн арга хэмжээнд оролцоход хэрэгтэй шаардагдах буудал, унаа, нислэгийн тийз зэргийг захиалсан. Мөн Нийслэлийг төлөөлөн явсан уран бүтээлчдэд шаардагдах нислэгийн тийз, буудал, унаа зэргийг шийдвэрлэн ажилласан. Япон Улсын Токио хотод 2024.09.26-29-ны өдрүүдэд олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн боллоо. Үзэсгэлэнд Монгол Улсаас нэгдсэн зохион байгуулалттайгаар 11 аялал жуулчлалын компани, байгууллага оролцлоо. Нийслэлийн	2024.01.01 2024.12.01	100%

11.	<p>Арга хэмжээ-2.4: Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжид заасан чиг үүргийг хэрэгжүүлэх, Төрийн албаны хууль болон терийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг мердэн ажиллах</p>	<p>Үйл ажиллагааны Хэрэгжилтийн хувь</p>	100%	100%	<p>Аялал жуулчлалын газрын эвент хариуцсан мэргэжилтэн Улаанбаатар театрын уртын дуучин, бүжигчин, морин хуурч хөөмийч З уран бүтээлчийг хариуцан тус үзэсгэлэнд засагдсан Монгол Улсын үзэсгэлэнгийн талбай дээр урлагийн тоглолт үзүүлэв. нийт 30 минутын 8 удаагийн тоглолтыг хийсэн. Мөн Улаанбаатар хотын сурталчилгааны 300ш сэтгүүлийг үзэсгэлэнг сонирхогчдод хүргэж сурталчилсан.</p> <p>Тайваний Олон улсын хамтын ажиллагааны хөгжлийн сан 2024.07.04-17-ны өдрүүдэд Тайваньд “Эко аялал жуулчлал” сургалт семинарт оролцов. Тус семинарт дэлхийн 20 улсын аялал жуулчлалын салбарын 27 төлөөлөгчид оролцож эко аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар тухайн улс орнуудын авч хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөр, аяллын бүтээгдэхүүн үйлчилгээг танилцуулах, судлах, тулгамдаад байгаа асуудлуудыг харилцан хэлэлцэж шийдвэрлэх зэрэг туршлага солилцов. Мөн Тайвань улсын аялал жуулчлалын салбарын эко аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар авч буй арга хэмжээнүүдтэй танилцаж, тухайн арга хэмжээг хэрэгжүүлж буй төрийн болон хувийн байгууллагуудын үйл ажиллагаатай танилцав. Тус газраас эвент хариуцсан мэргэжилтэн хамрагдав.</p>				
					<p>Ажил мэргэжилтэй холбоотой хууль, тогтоол, захирамж, журам болон байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, дотоод ажил үүргийн хуваарийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж, Албан хэрэг хөтлөлтийн журам, Архивын тухай хууль, холбогдох дүрэм, журмыг төрийн албаны стандартыг хэрэгжүүлэн анхаарч ажиллаж байна. Өөрийн ажил үүрэгтэй холбоотой өгсөн үүрэг даалгавар, шинэ мэдээ мэдээллийг удирдлагуудад танилцуулан, тухай бүр үнэн зөв мэдээллээр ханган биелэлтийг гарган ажиллаж байна.</p>	2024.01.15 2024.12.01	100%		

	хэрэгжүүлж ажиллах						
12.	Арга хэмжээ-2.5: Бодлогын баримт бичгийн тайлан өөрт хамааралтай гаргаж тайлагнах	Хэрэгжилтийн хувь	100%	100%	<p>Нийслэлийн Засаг даргын мэрийн хетелбер болон Нийслэлийн хөгжлийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан заалт болон Газрын даргын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, сайдтай байгуулсан гэрээний биелэлтүүдийн өөрийн албан тушаалын чиг үүрэгт хамаарах заалтын биелэлтийг 1, 2 дугаар улирал болон хагас жилээр гаргаж тайлагнасан.</p> <p>Мөн хагас жилийн хугацаанд зохион байгуулсан арга хэмжээ болон албан томилолтын 3 тайланг хуулийн хугацаанд нь гаргаж Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн.</p>	2024.01.01 2024.12.01	100%
13.	Арга хэмжээ-2.6: Дэлхийн аялал жуулчлалын хотуудын холбоо, Олон улсын эвентийн холбоо, Азийн явган алхалтын холбоонд элсэх замаар гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх	Гишүүнээр элссэн байгууллагын тоо	1	-	<p>Улаанбаатар хотод зохион байгуулж буй арга хэмжээний мэдээллийг нийтэлж олон улсад сурталчлан ажиллаж байна. Дэлхийн явган алхалтын холбоонд элсэх хүснэгтээ хүргүүлсэн ба 100 ам долларын хураамж төлөн нэг жилийн гишүүнчлэлийн эрх авах боломжтой болсон. Азийн явган алхалтын холбоотой байнгын хамтын ажиллагаатай ажиллаж байгаа ба 2025 оны төлөвлөгөөг цахимаар хамтран боловсруулахаар ажиллаж байна. Тухайн арга хэмжээнд тусгагдсан төсөв суугдаагүй тул үнэлгээнээс хасаж өгнө үү.</p>	2024.07.01 2024.12.01	-
Зорилт 3. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилтын хүрээнд:							
1.	Арга хэмжээ-3.1: Албан хэрэг хетлэлтийг заавар, дүрэм, журам, стандартын дагуу зохион бүрдүүлэн хетлех, ирсэн бичгийг цаг хугацаанд нь шийдвэрлэх	Шийдвэрлэлтийн хувь	100%	100%	<p>Албан хэрэг хетлэлтийг заавар, дүрэм, журам, стандартын дагуу зохион бүрдүүлэн хетлех, 16 ирсэн бичиг, 54 албан бичиг боловсруулж, харилцагч байгууллагуудад уламжилж, шийдвэрлүүлсэн байна. 4 захирамжийн төсөл боловсруулж, батлуулсан. Газрын даргын 4 тушаал бэлтгэсэн. Албан бичиг хугацаа хэтрэлт болон зөрчилгүй ажилласан.</p>	2024.01.01 2024.12.01	100%

2.	Арга хэмжээ-3.2: Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн өргөдөл хүсэлт, санал гомдлыг түргэн шуурхай, нэг мөр эцэслэн шийдвэрлэх	Шийдвэрлэлтийн хугацаа	100%	100%	Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн өргөдөл хүсэлт, санал гомдол 2024 оны байдлаар байхгүй болно.	2024.01.01 2024.12.01	100
3.	Арга хэмжээ-3.3: "Архив, албан хэрэг хетлэлтийн нийтлэг журам"-ын хүрээнд тавигдах стандарт, бурдэл, шаардлагын дагуу 2024 оны архивын материалыг хүлээлгэн өгнө.	Хүлээлгэн өгсөн тоо	3	-	Албан хэрэг хетлэлтийн журам, Архивын тухай хууль, холбогдох дүрэм журмыг баримтлан, хариуцсан ажлын чиглэлээр хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг гарган, бичиг баримтыг стандартын дагуу архивлаж ажиллаж байна.	2024.01.15 2024.12.01	100%

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
1.	Үүрэг даалгавар 1. Санал хүргүүлэн ажилласан Япон улсын Токио хоттой аялал жуулчлалын чиглэлээр хамтран ажиллах санал Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Гадаад харилцаа, хамтын ажиллагааны газарт хүргүүлсэн.	Шийдвэрлэх хугацаа			Нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон Токио хотын захирагаа хооронд 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдөр "Солилцоо, хамтын ажиллагааны тухай харилцан ойлголцлын санамж бичиг" байгуулсны дагуух Нийслэлийн Аялал жуулчлалын газраас хамтарч ажиллах саналыг хүргүүлж ажилласан. Нийт 4-н ажлын санал дээр плт бэлдэж хүргүүлсэн.	2024.06 2024.06	100%

2.	Үүрэг даалгавар 2. БНСУ-ын Койка буцалтгүй тусlamжын төсөлд 2 төсөл бичсэн	Шийдвэрлэх хугацаа	-	-	Тус газраас Бүгд Найрамдах Солонгос улсын Засгийн газрын буцалтгүй тусlamжийн хүрээнд 2026 онд хэрэгжүүлэх төслийн талаарх 2 саналыг англи болон монгол хэл дээр бичин хүргүүлсэн.	2024.06 2024.06	100%
3.	Үүрэг даалгавар 3. Газрын даргын албан томилотоор явсан хотуудын судалгааг хийсэн	Шийдвэрлэх хугацаа	-	-	Бүгд Найрамдах Солонгос улсын Сөүл, Гуанжу, Намянжу, Бүгд найрамдах Узбекистан улсын Ташкент хотуудад хийгдсэн албан томилотод хотуудын судалгааг хийж, ярилцах сэдвүүдийн талаарх санал боловсруулсан.	2024.01 2024.02	100%
4.	Үүрэг даалгавар 4. Жуулчин төгөл байгуулах ажлын хүрээнд мод, бут тарих	-	-	-	Шинэ Налайх цэцэрлэгт хүрээлэн"-д байрлах "Жуулчин төгөл"-д хамгаалалтын зурвасын хайлаас мод тарьлаа.	2024. 05.11	100%
5.	Үүрэг даалгавар 5. Төрийн албан хаагчид их цэвэрлэгээ хийв	-	-	-	<ul style="list-style-type: none"> - Нийслэлийн хэмжээнд зохион байгуулсан хаврын их цэвэрлэгээний ажлын хүрээнд 4-р сарын 11-13-ны өдрүүдэд "Гадаад харилцааны яамны урд уулзвараас Төв номын сангийн хойд уулзвар хүртэл хог хаягдлыг цэвэрлэн, дугуйн зогсоол, тамхины цэг, сандал зэргийг угааж, цэвэр цэмцгэр орчныг бүрдүүлсэн. - Сансрыйн И-мартын явган хүний замын цасыг цэвэрлэж иргэдийн тухтай зорчих нөхцөлийг бүрдүүлсэн. 	2024.01 2024.06	100%

6.	Үүрэг даалгавар 6. Койка олон улсын байгууллагаас санхүүжилт авав	-	-	-	- 2024 оны хугацаанд нийт 3000 ам долларын санхүүжилт авсан ба “Улаанбаатар” сэтгүүлийн англи хувилбар 500 хувь, Монголын газрын зураг 500 хувь нийт 1000 хувь хэвлүүлсэн. Мөн албан хаагчдад солонгос хэлний сурх бичгүүд хэвлүүлж, бичгийн хэрэгслүүдийг авсан.		
7.	Үүрэг даалгавар 7. Зүүн Хойд Азийн хотын дарга нарын форумын ажлын хэсэгт ажиллаж, модераторын үг бэлтгэсэн	-	-	-	Нийслэлийн Засаг даргын тамгын газартай хамтран Зүүн хойд азийн хотуудын дарга нарын эдийн засгийн форумыг 2024 оны 08 дугаар сарын 02- 04-ний өдрүүдэд Улаанбаатар хотод зохион байгуулж оролцсон. Форум нь 2 сэдвийн хүрээнд явагдсан ба 2 дугаар хуралдаанд Аялал жуулчлалын сэдвийн хүрээнд явагдсан ба үүнд гол илтгэгчийн сэдвийг бэлтгэн, хурлын үйл ажиллагааг бэлтгэсэн.		

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин					Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)		5		
	1	2	3	4					
1.	Арга хэмжээ 1. Солонгос хэлний мэдлэгээ дээшлүүлэх	Сургалтад хамрагдсан хугацаа	-	69 цаг	КОЙКА олон улсын байгууллагын хамтын ажиллагааны хүрээнд Солонгос хэлний анхан шатны хичээлд долоо хоног бүрийн 1,3,5 дахь өдрүүдэд 1цаг 20 минутын сургалтад хамрагдаж байна. Анхан шатны үсэг тоо, болон харилцан яриа сурсан. Мөн сайн дурын ажилтны хамтран ажиллагчаар ажиллаж байгаа.		2024.02 2024.12	100%	
2.	Арга хэмжээ 2. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хүний нөөцийн хөгжлийн	30 цаг	-	30 цаг	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хүний нөөцийн хөгжлийн төвөөс 2024 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр зохион		2024.01 2024.12	100%	

	төвөөс зохион байгуулж буй сургалтад хамрагдах				байгуулсан "Өөрчлөлтийн менежмент" 4-н цагийн сургалт, 2024 оны 02 дугаар сарын 22-ны өдөр зохион байгуулсан "Стресс менежмент" 8-н цагийн сургалт, 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр зохион байгуулагдсан "Mega хотын засаглалын шинэчлэл" 4-н цагийн цахим сургалт, 2024 оны 04 дүгээр сарын 30-нд зохион байгуулагдсан "Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого Алсын хараа 2050" 8-н цагийн сургалт, 2024 оны 09 дүгээр сарын 26-ны өдөр "Төрийн албан хаагчийн тасралтгүй хөгжих, гадаад улсад суралцаж мэдлэг мэргэшлээ дээшлүүлэхэд зориулсан тэтгэлэгт хөтөлбөрийн талаар мэдээлэл зөвлөгөө өгөх" 1 цагийн сургалт, 2024 оны 10 дугаар сарын 24-нд "Нийгмийн даатгалын эрх зүйн орчны шинэтгэл, хуулийн хэрэглээний талаар мэдээлэл зөвлөгөө өгөх" 4-н цагийн сургалт, 2024 оны 11 дүгээр сарын 07-нд "Төрийн албан хаагчийн ёс зүй хэм хэмжээ, манлайллыг дэмжих, ёс зүйтэй төрийн албыг бэхжүүлэх 1 цагийн сургалтад тус тус хамрагдаж нийт 30-н цаг сургалтад суусан.		
3.	Арга хэмжээ 3. Англи хэлний мэдлэгээ дээшлүүлэх, сургалтад хамрагдах	Гэрчилгээ авах	20 түвшин	20 түвшин	Wall street English 32 оронд 450 салбартай үйл ажиллагаагаа явуулдаг олон улсын англи хэлний сургалтын газарт хамрагдсан ба нийт 20-н түвшинтэй сургалтад шалгالت өгөхөд 17-р түвшин байсан. Тухайн сургалтад элсэн орж 20 дугаар шатны сургалттаа төгсөн шалгалац өгөн тэнцсэн.	2024.06 2024.11	100%
4.	Арга хэмжээ 4. Төрийн худалдан авах ажиллагааны мэргэшүүлэх А3 сургалтад хамрагдсан байна.	24 цаг	-	24 цаг	Төрийн худалдан авах ажиллагааны мэргэшүүлэх А3 сургалтад 2024 оны 04 дүгээр сарын 08-ны өдрөөс 04 дүгээр сарын 10-ны өдрүүдэд нийт 24 цагийн сургалтад хамрагдсан.	2024.04 2024.04	100%
5.	Арга хэмжээ 5. Монгол бичгийн чадвараа дээшлүүлсэн байна	Мэдлэгийн түвшин	Сайн	100%	Төрийн байгууллага 2025 оноос Монгол бичгийг албан хэрэг хөтлөлтөд хослуулан хэрэглэх болсонтой холбогдуулан Монгол	2024.01 2024.12	100%

					бичгийн тооны чадвараа дээшлүүлэхээр цахим хичээл үзэж судалсан. Үндэсний статистикийн газрын түвшин тогтоох шалгалтын сорил өгч сайн үнэлгээ авсан.		
--	--	--	--	--	---	--	--

ТАЙЛАН ГАРГАСАН:

ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГАА
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН
(Албан тушаал)

Д.САЙХАНЧИМЭГ / 
(Нэр, гарын үсэг)

2024.12.06

(Огноо)

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
4 дүгээр хавсралт

**ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙГ ХАНГУУЛАХ
ЯВЦЫН ЯРИЛЦЛАГЫН ТЭМДЭГЛЭЛ**

Албан хаагчийн овог, нэр: Дэлгэрсайханы Сайханчимэг

Ярилцлага хийсэн огноо: 2024 оны 12 сарын 01 өдөр

Ярилцлагын хэлбэр: 1.Биечлэн 2.Утсаар 3.Цахим хэлбэрээр

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хангалтгүй буюу эрчимжүүлэх шаардлагатай арга хэмжээний тухай	Нэгжийн даргаас өгсөн үүрэг даалгавар
-----	----------------------------------	---	---------------------------------------

Зорилт 1. "Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"

3.4 заалт. Улаанбаатарын онцлог бүхий аялал жуулчлалыг хөгжүүлж, эдийн засагт оруулах хувь нэмрийг нэмэгдүүлнэ

3.4.2. Аялал жуулчлалын салбарт инновацыг нэвтрүүлж, гадаад, дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлж, сурталчилгаа, маркетингийн ажлыг нэмэгдүүлнэ.

3.4.2.2. Улаанбаатар хотыг олон улсын аялал жуулчлалын үзүүлэлтүүдэд оролцож, сурталчилан таниулна.

Нийслэлийн 2024 оны төлөвлөгөө 158

1.	Арга хэмжээ-1.1: "Дэлхийн аялал жуулчлалын хотуудын холбоо"-той хамтын ажиллагааг өргөжүүлнэ.		Лондоноос с. докторийн байгуулж бүйрэгээ хамгийн ихийн мэдээлэл авт хамтраан ашиглан
2.	Арга хэмжээ-1.2: Улаанбаатар хотын аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг сурталчлах зорилгоор олон улсын арга хэмжээнд оролцож, зохион байгуулах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.		О.Ү-и чадгассаны арга нийтийг цархурт нийтийг нэвтрүүлж ирж чадгассаны арга нийтийг рөслийн орчинд замын ашигланах
3.	Арга хэмжээ-1.3: Найрамдалт харилцаат хотод Улаанбаатар хотын соёл, аялал жуулчлалын өдрүүдийг зохион байгуулах		Хөх хотод УБ хотын архивийн зорилог арга нийтийг нийтийн салын цэвэр аудио
4.	Арга хэмжээ-1.4:		

	Түүх соёлын дурсгалт 5 газарт Кью Ар /QR/ код уншуулж, цахим хөтчөөр дамжуулан мэдээлэл авах боломжийг бүрдүүлнэ.		
5.	Арга хэмжээ-1.5: Улаанбаатар хотын аялал жуулчлалын маршрут, зорин очих газрууд, жуулчдад зориулсан онцлох соёл, аялал жуулчлалын арга хэмжээг Эй Ар, Ви Ар /AR, VR/ технологиор хийж гадаад улс оронд сурталчлах/		

Зорилт 2. "Хуулиар олгосон чиг үүргийн хүрээнд"

Газрын дүрмийн 4.1.5. Нийслэлийн хөгжлийн бодлогод нийцүүлэн Улаанбаатар хотын аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр гадаад, дотоодын байгууллагуудтай хамтарч ажиллах;

1.	Арга хэмжээ-2.1: Олон улсын байгууллагуудтай хамтран төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах		У бхомын аялал нийцүүлэхийн бодлогод баруун байгууллагуудтай хамтарч ажиллах
4.1.9. Гадаад оронд зохион байгуулагдах аялал жуулчлалын хурал, зөвлөгөөн, үзэсгэлэн, арга хэмжээнд аялал жуулчлалын болон жуулчны үйлчилгээний байгууллагуудыг хамруулах;			
1.	Арга хэмжээ-2.2: Гадаад оронд зохион байгуулагдах үзэсгэлэн арга хэмжээнд байгууллагын оролцоог хангах		Гадаад оршидэг газар гаад ийл Улаанбаатар хотын цувралын төслийн цэвэртэй газар Улаанбаатар хотын цувралын төслийн замаар ялан, ОУ-ийн байгууллага, ОУ-ийн байгууллага шалтгаалж.
2.	Арга хэмжээ-2.3: Дэлхийн аялал жуулчлалын хотуудын холбоо, Олон улсын эвентийн холбоо, Азийн явган алхалтын холбоонд элсэх замаар гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх;		
3.	Арга хэмжээ-2.4: Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжид заасан чиг үүргийг хэрэгжүүлэх, Төрийн албаны хууль болон төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг мөрдөн ажиллах хэрэгжүүлж ажиллах		
	Арга хэмжээ-2.5: Бодлогын баримт бичигт туссан өөрийн чиг үүрэгт хамаарах мэдээллийг нэгтгэн тайлагнах		Гадаад оршидэг газар гаад ийл идэс мэдээ чадаах

Зорилт 3. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилтын хүрээнд:

1.	Арга хэмжээ-3.1: Албан хэрэг хөтлөлтийг заавар, дүрэм, журам, стандартын дагуу зохион бурдүүлэн хөтлөх, ирсэн бичгийг цаг хугацаанд нь шийдвэрлэх		
2.	Арга хэмжээ-3.2 Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн өргөдөл хүсэлт, санал гомдолыг түргэн шуурхай, нэг мөр эцэслэн шийдвэрлэх		
3.	Арга хэмжээ-3.3: “Архив, албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”-ын хүрээнд тавигдах стандарт, бүрдэл, шаардлагын дагуу 2024 оны архивын материалыг хүлээлгэн өгнө.		

ЯРИЛЦЛАГА ХИЙСЭН:

БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА
(Албан тушаал)

А.Рүүл / С.ТУУЛ /
(Нэр, гарын үсэг)